

МОНГОЛ УЛС ДАХЬ ХРИСТИИН ШАШНЫ ТҮҮХЭЭС

/Эртний улсуудын үеэс XIII зуун/

Б. МӨНХЗАЯА
Боловсрол Дээд Сургууль

Түлхүүр ойлголтууд: манихейн шашин, несториан шашин, католик шашин

Товчлол: Манай оронд шашин судлал нь 1990-ээд оноос марксизм-ленинизмийн үзэл суртлын хараат байдлаас ангид шинжлэх ухааны бие даасан салбар болж идэвхтэй хөгжиж байна. Энэ явцад бидний өмнө олон чухал зорилт, асуудал тулгамдан тавигдаж байгаагийн нэг нь монгол дахь христиин шашны түүх болон монгол хэлэнд орчуулагдсан библийн судрын орчуулгын түүхийн асуудал юм. Уг асуудлын хүрээнд эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл мэр сэргийгээн ч өнөө хүртэл ул суурьтай тусгайлан судлагдаагүй байна.

Би энэ өгүүлэлдээ монголын эртний улсуудын үе болон эзэнт гүрний үед христиин шашин хэрхэн дэлгэрч байсан, түүнд голлох үүрэг гүйцэтгэж асан номлогч болон жуулчдын талаар авч үзэх зорилт тавьсан болно.

Агуулга: Христиин шашин монголд 1990-ээд оноос дэлгэрсэн нь түүхийн хувьд цоо шинэ үзэгдэл хараахан биш ю и.

Монголын эртний улсуудын үед христиин шашны Манихейн(1) болон Несториан(2). Католик урсгалыг дэлгэрүүлэх оролдлого хийгдэж байсан тухай эх сурвалжийн болон археологийн мэдээ опон байдаг.

Эндээс ер нь өрнө зүгийн шашин суртахуун дорно дахинд анх хэдийд хөл тавив гэдэг асуудал бидний сонирхлыг татаж байна.

1623 онд Тан гүрний нийслэл Чань-ан буюу одоогын Хятадын Шаньси мужийн орчмоос 8 метр өндөр, 3 метр өргөн, 30 см зузаантай хар боржин чулуун хөшөө олдсон нь Ази дахь христиин шашны түүхийг хэдэн зуун жилээр урагшуулсан том нээлт болсон юм. Энэхүү хөшөөн дээр МЭ 630 онд Сирийн несториан шашны санваартан Алопен гэгч Торгоны замаар дамжин Хятадын Тан гүрний нийслэл Чань-ан-д ирж, эзэн хаан Тайцзунтай (МЭ 626-649) уулзсан тухай, өөрийн авчирсан несториан шашны ариун судрыг эзэн хааны номын санд орчуулсан тухай, несториан шашны Хятад дахь анхны сүмийг байгуулсан тухай бичсэн байдаг ажээ. Энэ бол христиан шашны санваартан Төв азид хөл тавьсан тухай анхны бодит түүхэн мэдээ болж байна.(3-34)

МЭ 781 онд Чин Чин-ий бүтээсэн эл хөшөө нь оройн хэсэгтээ бадамлянхуа суурин дээр загалмай залсан, 1756 хятад ханз, Сири, Перс номлогчдын нэрийн жагсаалт бүхий 70 Сири үгийг багтаасан байх агаад агуулгын хувьд христиин шашны сургаал номлолын тухай, Алопен болон

МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

Перс номлогчдын Хятадад ирсэн тухай, МЭ 638-781 он хүртэлх Хятад дахь несториан шашны хувь заяны тухай өгүүлсэн байдаг ажээ.(4-291)

МЭ 638 онд Тан гүрний нийслэл Чань-ан-д христийн шашны анхны сүм баригдаж, түүнээс хойш энэ тоо нэмэгдсээр VII зууны сүүлийн хагас гэхэд 358 болж өсчээ.

Хятад хэлэнд бичигдсэн 9 несториан шашны гар бичмэл одоогоор бидэнд олдоод байна. Үүнээс "Бишоп Аlopений баримтууд" (The Bishop Alopene documents) гэж нэрлэгддэг 4 ном нь несториан номлогчид хятадад ирсэн эхний жилүүдэд, "Бишоп Сириакусийн баримтууд" (The Bishop Suriacus documents) гэж нэрлэгддэг 4 ном нь VIII зуун буюу несториан хөшөө бичигдсэн үетэй холбогддог бол үлдсэн нэг ном нь нэлээд хожуу буюу X зууны сүүл XI зууны эхэн үед холбогддог байна.

"Бишоп Аlopений баримтууд"ын нэг болох хятад хэл дээр орчуулагдсан христийн шашны анхны гар бичмэл "Jesus-Messiah Sutra"-г 1922 онд Японы эрдэмтэн Ж.Такакусу нээн илрүүлж, түүнийг нь эрдэмтэн Сэйки МЭ 635-638 онд Аlopен орчуулсан гэж үзсэн байна.(5)

Тан гүрэнд несториан санваартан хөл таёснаас арай хожуу буюу МЭ 694 онд манихейн шашинтан Фү Түвэ Ян мөн таргоны замаар дамжин Тан гүрэнд ирсэн бөгөөд МЭ 732 онд эзэн хаан Хуанцзун (712-756) өөрийн улсдаа манихейн шашныг дэлгэрүүлэхийг зөвшөөрсөн зарлиг буулгаж байжээ.

МЭ 755 онд Тан улсад Лу Шаны бослого гарч , түүнийг дараход өөрийн хүч үл хүрсэн тул Тан улсын хаан Монголын өндөрлөгт оршин тогтнож байсан Уйгурын хаант улсаас цэргийн тусlamж гүйсны дагуу МЭ 762 онд Уйгурын цэрэг бослогыг дарсан байдаг. Энэ үед Уйгурчууд манихейн санваартантай анх танилцаж, зургаан санваартныг нийслэл хот Хар балгасандаа урьж аваачсан төдийгүй удалгүй өөрсдөө манихейн сүсэгтэн болж хаант улсынхаа төрийн шашин болгожээ.(6-164)

МЭ 840 онд Уйгурчууд Монголын өндөрлөг дээрх эрх мэдлээ Киргизүүдэд алдаж Шинжаан тийш нүүсний дараа тус шашин ч мөн баруун тийш нүүсэн байна.

Тухайн үедээ эртний Шинжаан нь манихейн шашинтуудыг хамгаалах орон болж манихейн шашинтуудыг хавчин дарлах үед Шинжаан дахь Уйгурын хан нь чанга цохилт өгдөг байлаа.

Жишээ нь: X зууны эхээр Уйгурын ван Хорашан-ы нэг ноёнд өгсөн бичигтээ: "Миний нутаг дээр муслиимийн мөргөлтний тоо эрхэм улсын

нутаг дээрх манаи шашны мөргөлтний тооноос хол илүү байна. Хэрэв та нэг л манихейн мөргөлтнийг хорооход хүрээл би заавал муслимийн мөргөлтөн бүхнийг хороож байгаад өшөө авна. Лалын сүмийг тэгш газар болгон дөрвөн зүгт хүн томилон мөргөлтөн нарыг нь ална “ гэсэн нь буй.(7)

Манихейн шашин нь Уйгурчуудын дунд хэдэн зуун жилийн турш оршин тогтнож байгаад сүүлээр нь доройтсон билээ.

Тус шашин Уйгурчуудын дунд дэлгэрсэн нь Уйгурын соёлын түүхэнд ихээхэн нэлөө үзүүлсэн байна. Манихейн лам нар өөрсдийн сургаал номполоо Уйгурчуудын дунд дэлгэрүүлэх зорилгоор согд үсгийг авчран судар номыг бичсэнээр Уйгурчуудыг боловсронгуй бичиг үсэгтэй болгосон гэж үзэх нь бас бий.(8-411)

Манихейн шашинтуудын Уйгур, Түрэг хэлэнд бичиж үлдээсэн нэлээд олон судрууд Дунхуан болон Турфаны хөндлийгээс олдож, түүнийг нь Пеллио авгай зэрэг эрдэмтэд судалсан байдаг.

МЭ-ний 843, 845 онд Тан улсын бүмбүн шашинт хаан Ү Зүн харийн бүхий л шашин суртахууныг хавчиж, хөөн гаргах зарлиг буулгажээ.

Энэхүү хавчлаганд Манихейн шашинтууд хамгийн анх өртсөн бөгөөд хааны зарлигаар Манихейн шашны ном судруудыг хураан авч шатаасан төдийгүй Манихейн 70 санваартныг Чань-ан-д егүүтгэсэн ажээ.

Эртний Тан улсын тэмдэглэлд бичсэнээр энэ үед эзэнт гүрний хэмжээнд харийн шашны 4000 сүм хийд, 40000 даяанчийн агуяа, 265500 санваартан нар байсны, сүм хийд бүгдийг хааж устган, лам санваартныг нь эх нутгаасаа хөөн гаргажээ.(9-304)

Ийнхүү несториан шашны номлогчид өдтэдээд үйл ажиллагаагаа явуулах бололцоогүй болсноор монголын өндөрлөг газарт нүүдэллэн ирсэн байна.

Монголын эртний улсуудаас Уйгурүүд манихейн шашныг, Хэрэйд несториан шашныг, Онгут католик (эхэн үедээ несториан) шашныг тус тус шүтдэг байсан тухай археологийн болон эх сургуулжийн мэдээ баримт олон бий.

Хэрэйд аймгийнхан несториан шашныг шүтдэг байсан тухай Рашид ад дин “Судрын чуулган” зохиолдоо “Есусийн уриа тэдэнд хүрч тэд /Хэрэйдүүд/ түүнийг шүтжээ. Тэд өөрсдөө Монголчуудын төрөл /овог/ юм. Нутаг нь монголчуудын нутаг Онон, Хэрлэ “ юм гэж тэмдэглэжээ.(10-190) Хэрэйд аймгийнхан анхлан бүр МЭ XI зууны үед несториан шашинтай учирсан байна.

Энэ тухай Сирийн түүхч Бар Хэврэүс 'Он дарааллын бичээс"-дээ: "Хэрэйдийн ван хааны өвөг Буйрук хаан өндөр ууланд ан гөрөө хийж яваад замаа алдан төөрч, итгэл найдвараа алдан байх үест нэгэн несториан шашны санваартантай тааралдаж зам асуухад: "Хэрвээ чи Христэд итгэвэл би чамайг аваръя" гэжээ. Хаан эсэн мэнд гэртээ ирээд хэсэг христиин шашинтан худалдаачидтай уулзах үед болсон явдлыг санан тэднээс өөрсдийнх нь итгэл бишрэлийн талаар асуухад: "Хэрвээ та баптизм хийлгэхгүй бол аврагдаж чадахгүй" гээд түүнд болон түүний аймгийнханд баптизм хийх санваартан шаэрдаж Мервийн несториан метрополитан Ебедаяшуд илгээлт илгээхийг зөвлөсөн" тухай тэмдэглэжээ.

МЭ 1009 онд Ебедаяшугаас Багдад дахь несториан патриарх 6-р Иоан-д бичсэн захидлаас үзвэл Буйрук хаан хоёр зуун мянган түрэг Хэрэйдүүдээ дагуулан христиин шашинд орсон байдаг.(11)

Энэ үед өرنө дахинд буюу христийн шашны ертөнцөд пресвитер Иоаны (John) тухай домог яриа дэлгэрсэн ажээ. Хэрэйдийн Ван хан буюу түүнээс өмнөх Ван нар нь европын христиин шашинтнуудын дунд пресвитер Иоан гэж хүндлэгдэн дорно дахины христиин шашин шүтэгчдийн дотор байр сууриар нэлээд дээгүүрт орж, христиин шашны ирээдүйн аврагч гэж үзэгдэж байв.

"Пресвитер Иоан хаан өөрийн цэргүүдээ удирдан удахгүй ирж загалмайтын цэрэгт туслан христиин ертөнцийг аварна" гэсэн эл домыг 1145 онд Европын он дараалсан бичигт тэмдэглэж оруулсан байна. Энэ нь Хэрэйд аймаг несториан шашин шүтсэний дараах 140 жилд тохиож буй тул энэ хугацаанд тус домог европчуудын дунд нэлээд тархсан ажээ.(12-171)

Эзэнт гүрний үе болон Юан гүрний үед Монголчууд несториан болон католикийн шашинтнуудыг "дарса" болон "эркэгүн", "эркэүн" олон тоон дээр "эркэгүд", "эркэүд" буусу хутагт, номлогч гэж нэрлэж байв.(13)

Несториан шашны лам нарыг Сири хэлний дуудлагаар Мар-Хасиа буюу Богдын элч, Раббан буюу номч багш гэж нэрлэж байв.

Одоо Өвөр Монголын Ордост эрхүүд тэж аймаг байх агаад тэнд оршуулгын ёслолыг несториан шашны зан үйлээр гүйцэтгэж, цогцсыг загалмай хэлбэрээр оршуулдаг байна.

Монголын өндөрлөг дээрх өөр нэгэн томоохон аймаг болох Онгут аймгийнхан несториан шашин шүтдэг байсан тухай Марко Поло, Монтекорвино, Ордорик де Порденоне нарын аяллын тэмдэглэл, Дайдугаас

Иль хаант улс хүртэл аялсан несториан санваартан Саум, Маркус нарын намтрын мэдээнд тодорхой бичсэн байдаг байнэ.

1929 онд Свен А. Хединээр удирдуулсан Шведийн экспидицийнхэн Юан гүрний үеийн Онгут аймгийн нийслэл Олон сүмийн (Olon-Sume) /Koshang гэж алдаршсан/ үлдэгдлийг олж илрүүлсэн юм.

1933 онд америкийн эрдэмтэн О.Латтимэри Олон сүмийн үлдэцэд судалгаа хийж, загалмайн дүрс бүхий олон тсоны чулуу олж илрүүлсэн бөгөөд тэдгээрийг несториан шашны дурсгалын нэг гэж үзсэн.

Хожим 1936 онд Эрих Хэйниш Вунчуаны ойролцоо газраас олон сүмийнхтэй ижил загалмайн дүрс бүхий булшны чулуу, Десмонд Мартин Шар мөрний зүүн эрэгт орших Вангму хэмээх оршуулгын газраас несториан загалмай бүхий 17 ширхэг булшны чулууг тус тус олж илрүүлсэн байна. Олон сүмийнхээс ялгаатай нь загалмай, цэцэг, навчны дүрс бүхий эдгээр булшны чулуун дээр нас барагсдыг несториан шашинтан байсан гэдгийг харуулсан Сири бичээстэй байжээ. Эдгээр загалмайн дүр бүхий булшны чулуунууд нь бүгд боржин чулуугаар хийгдсэн бөгөөд толгойн хэсэгт байрлах несториан загалмайг лянхуа цэцэг бүхий суурин дээр байрлуулсан байна.(14-16)

Несториан шашны булшны чулуу бэлон бусад археологийн дурсгалуудаас үндэслэн Онгутын эзэн хааны нийслэл Кошанд Маркусын (1245-1317) эцгийн үед несториан сүм баригдсан бололтой гэж үздэг байна. Энэ сүмд несториан шашинтан онгут хүмүүсийн булшны чулууг хадгалдаг өрөө байсан байж болох юм гэж эрдэмтэн О. Латгимор үзжээ.

Олон сүмээс олдсон булшны чулуун дээсөх загалмайн дүрс нь Грек загалмайн хэлбэртэй буюу хэрээсийн урт нь ижил хэмжээтэй, үзүүр лүгээ нарийссан байх ажээ.

Онгут аймгийнхан христийн шашинтан байсан гэдгийг харуулах өөр нэг баримт бол энэ аймгийнхан дунд Жеорж, Симеон, Поль, Жан, Констан, Антониус зэрэг нэртэй хүмүүс цөөн биш байсан явдал юм.(15)

Монголын эртний томоохон аймгуудын нэг Найман аймаг эхэн үедээ несторийн шашинтан байсан тухай Жувейн "Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх" бүтээлдээ өгүүлсэн байдаг.

1980 онд археологич Д.Баяр Ховд аймийн Мөнх хайрхан сумын Улаан толгой хэмээх газраас христийн шашны зэгалмайн дүрс бүхий хадны бичээс олж илрүүлсэн бөгөөд сайхь бичээсийг Найман аймгийн нутгийн хязгаарт багтаж буй тул Найманы несториан шашинтны үлдээсэн дурсгал болов уу гэсэн таамаглалыг дэвшүүлжээ.(16-10)

МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

Эзэнт гүрний үед Монголчууд Ази, Европыг дайлан явахдаа эзэлсэн улс орныхоо соёл, шашин суртахууныг алагчлан үзэлгүй харин ч бүгдийг тэгшээр дэмжин тэтгэж байжээ.(17) Иймээс Монголчуудад эзлэгдсэн аль ч орны соёл тасралгүй хөгжсөнөөр барахгүй зарим тасалдаад байсан соёл сэргэн хөгжсөн байдаг.

Жишээлбэл МЭ 845 онд Ү Зүн хааны харийн шашин суртахууныг цаазлах бодлого явуулснаар хавчигдан шакагдаад байсан несториан шашинтнууд Чингис хааны дотор газрыг байлдан эзэлсний ачаар сая дахин дэлгэрсэн аж.

Чингис хааны алтан ургийнхан несториэн шүтлэгт овог аймгуудтай /ялангуяа Хэрэйд, Онгут аймгийнхантай/ гэрлэлтээр цусан төрлийн холбоо тогтоосноор зарим хаад хатад, тэдний удмынхан несториан шашин шүтдэг эсвэл несториан шашинд элэгтэй ханддаг байсан тухай жишээ баримт олон байдаг. Тулуйн хатан Сорхонтань, Хүлэгийн хатан Төгс, Зүчийн хатан Бектутмиш, Мөнхийн хатан Хөхдэй, Батын хүү Сартах нар несториан шашинтан байсан бол Онгут аймгийн католик шашинтан ван По яо хо Чингисийн охин Алаха бэхийг, Хүн буха Гүегийн охин Елмишийг, Ай бух Хубилайн охин Юрэкийг, Жеоржес Хубилай хүү Чэнгийн охин Аяшиш гүнжийг эхнэр болгон авсан, мөн Чингис хааны шадар сайд Чингай чинсан тэргүүтэй өндөр тушаалын зарим сайд, түшмэд несториан, католикийн шашинтан байсан тухай өрнөдийн болон Арабын аялагч, эрдэмтэд болох Плано Карпини, Гильом де Рубрук, Марко Поло, Монтекорвино, Рашид ад дин, Бар Хэврэүс, Ата Малик Жувейн нарын тэмдэглэлд дурьдагсан нь бий.

Юан гүрний үед несториан шашинтнууд хааны шадар сайд, цэргийн жанжинаас эхлээд цэрэг, гар урчууд, ажилчин, тариачин гээд янз бүрийн ажил эрхэлж, нийгмийн давхарга бүрт уусан шингэж улмаар нийгэмд христийн шашинтан хэмээх нэгэн бүлэг маятай зүйлийг бий болгожээ. Тухайн үед Юан улсын хэмжээнд несториан шашны 72 сүм хийд, 30000-аас илүү несториан шашинтан байсан бөгөөд тэд Онгут, Тангут, Хятан зэрэг шашны тойрот харьяалагдан захирагдаж байв.

Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзээд Хубилай хаан 1289 онд тусгайлан несториан шашинтан болон несториан сүм хийдийн хэргийг хариуцан ажиллах яамыг байгуулж тэргүүнээр нь Нгай-сие-г томилж байжээ.(18)

Монголын эзэнт гүрний хаадууд христийн шашны дээд лам нартай захиагаар харилцаж байсан түүх арвин байдгаас Хубилай хааны несториан

шашинтан Саумыг(19) Ромын пап-д элч болгон илгээсэн түүх тодоор үлджээ. Үүнд: "Их хаан даруй апостол санваартанд долоон эрдэм нэвтэрхий мэргэшсэн, аливаа ном хаялцаж үг мэтгэхүйд чадамгай, билиг цэцэн 100 орчим христосын санваартныг явуулна уу, мөн Иерусалим дахь хамгийг тэтгэгчийн бунхны өмнөх зулын тосноос адислан авчрагтун" хэмээн даалгасан байна.

Энэ мэдээ өرنө дахины христийн шашинтуудад олдошгүй ховор мэдээ болжээ. 1289 оны 7 сард пап лам Николас IV Иль хаант улсад шашин дэлгэрүүлэх ажил хийгээд ирсэн франциск лам Монтекорвино-г Юан улсад шашин дэлгэрүүлэхээр томилон илгээв. Тэрээр 1294 онд Дайдуд ирэхэд Хубилай хаан нас нөгчсөн тул бичиг сэлтээ Төмөр хаанд өргөн барьсанд Төмөр хаан түүнд Дайду хотод сууж шашин дэлгэрүүлтүгэй хэмээн зарлиг буулгав.

Монтекорвино 1305 онд Дайдугаас Пап-д илгээсэн захиандаа "Хойд хятадад ирсэн жилдээ Онгут аймгийн Жеоржис нэртэй хаантай уулзан, түүнийг несториан шүтлэгээс нь католик шүтлэгтэн болгосон тухай, онгут хүмүүсийн ихэнх нь хааны тусlamжтайгаар католик шашинд орсон тухай, Онгут аймгийн хаан өөрийн нийслэлдээ бурхан, ариун гурвал, католикийн пап-д зориулж гоёмсог сүм бариад түүнийгээ Эклесиа Романа гэж нэрлэсэн тухай, эзэн хааны нийслэл Дайду хотод хонх, загалмай бүхий цамхагтай, 200 хүний багтаамжтай мөргөлжийн танхимтай хоёр сүм барьсан тухай, тэндээ шинэ гэрээний зарим ном, мөргөлийн дууллыг монгол хэлнээ орчуулсан тухай, 6000 хүнд усан баталгаа хийсэн" (14-115) тухай бичсэн байна.

Монтекорвино тус захиандаа эрдэм чадагтай лам томилон илгээхийг хүссэний дагуу пап лам франциск урсгалын 7 ламыг түүнд туслагч болгон илгээснээс Андре де Перузе, Жерард Албуйни, Лерегрино да Кастелло нар л Дайдуд хүрсэн ажээ.

Андре де Перузе 1326 оны 1 сард Ромын Пап-д илгээсэн бичигтээ: "Монголын хаадууд шашны номлогчдыг ивээн тэтгэдэг тухай, Их хаан Есөнтөмөрийн зөвшөөрлөөр зуун алтан флюрины хөрөнгөөр тусгай сургууль байгуулсан тухай, Дайдуд гурав дахь католикийн сүм баригдсан тухай, өөрөө сүм дуган, уулын агуй хоёрын хсоронд цаг завгүй ажиллаж байгаа" тухайгаа бичжээ.(20-98)

Юан гүрний үеийн католик шаши номлогчдын дотроос Монтекорвино, Андре де Перузегийн дараа орох хамгийн алдартай номлогч бол франциск урсгалын Ордорик де Порденоне байв.(20) Тэрээр Дайду-д

гурван жил шашин дэлгэрүүлэх ажил хийж байгаад 1328 онд нутаг буцсан бөгөөд түүнийг явсны дараах жил нь Монтекорвино нас нөгчсөн байна.

1336 онд Тогоонтөмөр хаан Ромын пап-д, бичсэн захидалдаа: "Дайду хотын Католик шашны гол хүн Монтекорвино нас бараад 8 жилийн нүүр үзэж байна. Католик шашныг Дайду хотод дэлгэрүүлэхийн тул эрсэм чадалтай нэг санваартныг тохируулан ирүүлэх нь зүй" гэсний дагуу Мариgnolli тэргүүтэй санваартныг Юан улсад томилсон байна. Мариgnolli 1342 оны 7 сард Шанду хотод ирж эзэн хаанд бараалхан папын захиа, бэлэг сэлт болон нэгэн усан хар морийг бэлэглэжээ.(21) Мариgnolli тэргүүтэй 32 хүн Дайду хотод католик шашныг дэлгэрүүлж байгаад 1345 онд нутагтаа буцсан байна.(22)

Үүний дараагаар Пап V Уrbain Гийом де Прато зэрэг номлогчдыг Юан улсад томилсон боловч энэ үед Хятад дахь Монгол хаадын үе нэгэнт шувтарсан байлаа.

Юан улс унасны дараа Хятадууд христийн шашныг Монголчуудын оруулсан, ивээн тэтгэсэн харийн шашин гээд сүм дуганыг нь нураан эвдэж, лам санваартныг нь эх нутгаасаа хөөн гаргасан байна.

Summary

Christianism began to spread in Mongolia in 1990 and it was not a new phenomenon to Mongolians. According to the historical sources and archaeological news, during ancient Mongolians tribes Christian Manichaeism, Nestorianism and Catholicism spread between Kerait, Naiman, Merkit and Ongut tribes.

At the Mongol Empire and Dynasty of Yuan, when Mongolians attacked through the Asia and Europe, they were not discriminating culture and religion of occupied countries but were supporting them.

So Christian Nestorianism and Catholicism were spreaded and church was built, bible was translated by Mongolian language in the Daidu.

Ишлэл, зүүлт

1. Манихейн шашныг үндэслэгч Мани МЭ 215 онд Вавилонд төржээ. Тэрээр 12 насандаа зөн билгийг мэдэрч, 24 настайдаа өөрийн сургаалиа номлож эхэлсэн байна. Манийн сургааль эхэн үедээ Персийн нутагт нэлээд нөлөөтэй байсан ч Зороастрын санваартан нарын хавчлагаар нөлөө нь суларч улмаар Маниг 277 онд цаазаар авсан байна. Тус шашны онолын үндэс нь зорастризмын сайн хийгээд муугийн тухай сургаал, гностикийн (христийн шашны анхны нийгэмлэгүүдийн нэг) гэгээн оюун санаа хийгээд харанхуй нүгэлт орчлонгийн тухай сургаалийн сайтар боловсруулсан нэгдэл юм. (Eurasian studies year book, № 68, 1996) Манихейн шашны үзлээр нэг удаа гэнэтийн гай гамшиг болж салангид байсан гэгээн харанхуй хоёр нь нэгдсэн гэдэг. Иймээс хүн бүр чанга хатуу бясалгал хийж цэвэр ариун санааг өөртөө төрүүлэх хэрэгтэй бөгөөд ингэхийн тулд гурван цээр (аман, гар, цээжин), арван сахилыг (хөрөг тахих, их үг хэлэх, тачаах, амьтан алах, хурьцал үйлдэх, хулгай хийх, бусдыг мэхлэх, гажуу увьдас гаргах, хоёр сэтгэл, залхуу, сэжиг үгүй байх) сахих, өдөр бүр 4-7 удаа залбирч, мацаг барин нүглээ наминчлэх хэрэгтэй ажээ. (А.Түмэн Монголчууд хийгээд дэлхийн гурван их шашин, Өвөр Монголын үндэсний хэвлэлийн хороо.,2001, Манийн сургаал Хятад, Ром, Хойд Африк, Франц, Монголд дэлгэрч байжээ. Jerald C.Beauer, Dictionary of church history , USA.,1998)
2. Несториан шашныг үндэслэгч Нестор МЭ 415 онд Антиох хотод төрж, 428 онд Константинополийн патриархаар ажиллаж байжээ. Тэрээр "Bazaar Heracleides" гэдэг ганц зохиол туурвисан. (Eurasian studies year book, № 68, 1996) Нестор "Есүс бол тэнгэрлэг хэсэг, хүний хэсэг гэсэн хоёр мөн чанартай. Мари бол бурханы ээж биш зөвхөн хүний биеийн хэсгийн л ээж юм" гэж үзжээ. Несториан шүтлэг нь Азид хамгийн их дэлгэрсэн бөгөөд XIII зуунд оргилдоо хүрсэн байна. Энэ үед Азид 25 архибишоп, 200 бишоп байжээ. (Jerald C.Beauer, Dictionary of church history , USA.,1998, А.Түмэн Монголчууд хийгээд дэлхийн гурван их шашин, Өвөр Монголын үндэсний хэвлэлийн хороо.,2001)
3. Hugh P.Kemp, Steppe by Step /Mongolia's Christians from ancient roots to vibrant young church/ London.,2000
4. Samuel Hugh Moffett, A History of Christianity in Asia, NY.,2004

5. мөн тэнд
6. А.Түмэн, Монголчууд хийгээд дэлхийн гурван их шашин, Өвөр Монголын үндэсний хэвлэлийн хороо.,2001
7. мөн тэнд
8. Samuel Hugh Moffett, A History of the Christianity in Asia, NY.,2004
9. Samuel Hugh Moffett, A History of the Christianity in Asia, NY.,2004, Эрдэмт, Монгол бөөгийн шашин жич үзэл санааны түүх, Өвөр Монголын Үндэсний Хэвлэлийн Хороо.,2001
10. Ч.Жүгдэр, Монголд феодлизм тогтох үеийн нийгэм-улс төр гүн ухааны сэтгэлгээ, УБ.,1987
11. Howorth.H.H, The Northern Frontagers of China, London.,1889 Hugh P.Kemp, Steppe by Step /Mongolia's Christians from ancient roots to vibrant young church/ London.,2000, Samuel Hugh Moffett, A History of the Christianity in Asia, NY.,2004, А.Түмэн, Монголчууд хийгээд дэлхийн гурван их шашин, Өвөр Монголын үндэсний хэвлэлийн хороо.,2001
12. А.Түмэн, Монголчууд хийгээд дэлхийн гурван их шашин, Өвөр Монголын үндэсний хэвлэлийн хороо.,2001
13. мөн тэнд
14. Namio Egami, The Mongol empire and Christendom San Paolo.,2000
15. мөн тэнд
16. ШУ амьдрал, № 6, УБ.,1987
17. Эзэнт гүрний үеийн Монголын хаад нь тухайн үед бүхий "тойн" Бурханы шашин, "эрхүүд" христосын шашин, "ташмад" Исламын шашин зэрэг шашин суртахууныг алагчлан үзэлтүй "харин бүгдийг тэгшээр дэмжин" тэтгэж байсан тухай мэдээ олон бий. (Цоож, Монголын бурханы шашны түүх, Өвөр Монголын хэвлэлийн хороо., 1998) Жишээ нь Дайду хотод католикийн шашныг дэлгэрүүлж асан Одорик де Порденоне Ромын пап-д илгээсэн захиандaa: "Түм түжигнэж, бүм бужигнасан энэ их хотод хятад, монгол, будда, нестор, лалын шүтлэгтэн зэрэг зүсэн бүрийн хүмүүс холилдон амьдарч байгааг өгүүлэхийн ялдамд монгол засаг захиргааны ёс дэгийг хүндэтгэн" янз янзын яс үндэстний хүмүүс энх амгалан нийцэн амьдарч тэднийг захиран зохицуулж чадаж байгаа нь дэлхийн хамгийн гайхамшигт үзэгдлийн нэг мэт санагдана" гэжээ.
18. Нгай-сие (1227-1308) бол Гүег, Мөнх, Хубилай зэрэг хаанд хүчин зүтгэж байсан несториан шашинтан оточ, зурхайч, хэлмэрч, шашны номлогч хүн юм. Нгай-сие гэдэг нь арабаар Исэ, европоор Иисус гэдэг үгний хятадаар

галигласан нь ажээ. 1236 онд Нгай-сие одон орон судлалын төвийн захирлаар ажиллах болсон бөгөөд түүний өрэгцээ несториан шашны сүм хийд байгуулан, несториан шашныг дэлгэрүүлэх тал дээр чармайн ажиллаж байжээ. Нгай-сие 1279 онд Хубилай хааны Хятадын дотор Ислам сургаалыг сурталчлан дэлгэрүүлэхийг хориглосон зарлигыг гаргахад голлох нөлөө үзүүлсэн хүн юм. 1276 онд өмнөд Сүн улсыг мөхөөгөөд ирэхэд Нгай-сие Хубилай хаанд: "Муслимчууд Монголчуудын алсан малын маҳыг идэхгүй заавал амьд хөнь авчирч өөрийн шашны ёсоор алсан хонины маҳыг идэж хонины гарзыг их гаргаж байна" гэснээр эзэн хаан Муслимчуудыг ямар ч маҳыг идэх болгож, хэрвээ муслим зарлигийг зөрчвэл алаар ялаар шийтгэх болжээ.

19. Раббан Саум (? - 1294) нь несториан шашны том лам төдийгүй монгол-европын элчийн харилцаанд томоохон үүрэг гүйцэтгэсэн хүн юм. Тэрээр несториан шашинтан онгут гэр бүлд терж 20 часандаа гэрээс гарч дайду орчимын ууланд бясалгал хийж байхдаа Маркустай танилцсан ажээ. Тэд хоёулаа хамтаар Иерусалим орж несториан шашны тэргүүн ламд мөргөхөөр 1275 онд Дайдугаас гарсан ч Сирийн нутагт байнгын дайн дажинтай байсан учраас тэдний аялал Иль хаант улс хүрээд зогссон байна. Тэд Иль хаант улсад Персийн несториан шашны тэргүүн санваартан Мар Динхаха-тай уулзсан бөгөөд тэрээр Маркусыг Дайду хийгээд Онгут аймгийн шашны тэргүүн санваартнаар, Саумыг ерөнхий санваартнаар томилжээ. 1281 онд Мар Динхаха нас нөгчиж Маркус шинэ тэргүүн санваартнаар томилогдож III Мар Яхбалаха болсон байна. 1287 онд Аргун хаан болон их хаан Хубилай Саумыг Ромын пап, Франц болон Английн хаанд элч болсон зарсан юм. Саум тэргүүтэй элч Константинополиор дамжин Ром, Перст хүрч Францын хаантай уулзан, Францын баруун өмнөд хэсэгт орших Бордо хотод Английн хаантай уулзан, буцахдаа 1288 онд Ромын пап лам Николас IV-тэй уулзан Аргун хаан болон их хаан Хубилайн захидал, бэлгэ сэлтийг гардуулсан байна. Саум үүргээ амжилттай биелүүлээд буцаж ирсэний дараа Аргун хаан Саумыг сайшаан Табриц дахь шинээр байгуулсан сүмийн тэргүүн санваартнаар томилжээ. 1293 онд Саум Багдад хүрч III Мар Яхбаллахатай хамтран ажиллах болжээ. 1887 онд Сири хэлэнд бичигдсэн "III Мар Яхбалаха болон Раббан Саумын намтар"-ыг олж илрүүлснээр Саумын хийсэн аялал дэлхий дэхинд тодорхой болсон юм. (Montgomery.J.A, The History of Yaballaha III, Nestorian Patriarch, and of his

МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

Vigar, Bar Sauma, Mongol Ambassador to the Frankish Courts at the End of the Thirteenth Century NY.,1927)

20. Ренэ Груссе, Чингис хааныхны Монголчууд, УБ.,2004
21. Мариgnolli Тогоонтөмөр хаанд Папын өгсөн бэлэг сэлт болон 8 тохой өндөр усан хар морийг эмээл хазаартай нь өргөн барьсанд эзэн хаан ихэд баярлаж “тэнгэрийн хүлэг” гэж нэрийдэн шүлэгч залж шүлэг зохиолгон, зураач залж морийг зуруулсан байна. Тэнгэрийн хүлгийн зураг нь Цин улсын Сайшаалт, Ерөөлт хаадын үед хааны дотоод ордонд хадгалагдаж байжээ.

Мариgnolli 1353 онд Германы ван IV Карлын урилгаар франкт очиж Пүшимиya-ны он дараалсан бичгийг хариуцан бичсэн бөгөөд тус бичигт өөрийн дорно дахинд ажиллаж байсан тухайгаа тусгайлан бичжээ.